



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/158

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн 2019 оны төсөв батлах тухай Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01- ний өдрийн 8/04 тогтоолын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Радио телевизийн Үндэсний сүлжээний Баян-Өлгий аймгийн Радио телевизийн сүлжээний газартай Ховд аймгийн Орон нутгийн 4 телевизийн нэвтрүүлгийг 200Вт чадалтай дахин дамжуулах станцаар дамжуулж иргэд, хэрэглэгчдэд хүргэхээр байгуулсан гэрээний дагуу “Телевизийн нэвтрүүлэг дамжуулсны түрээсийн төлбөр” болох 6.0 сая төгрөг /Зургаан сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээ”-ний 3.5 дахь заалтад тусгасан Орон нутгийн телевизийг дахин дамжуулах сүлжээнд холбох зардлаас гаргасугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийг дахин дамжуулалтын чанар, тогтвортой байдлыг хангах үүднээс 2019 оны 3 дугаар сард 50,0 хувь буюу 3,0 сая төгрөг /Гурван сая/-ийг, үлдсэн 3.0 сая төгрөг /Гурван сая/-ийг мөн оны 7 дугаар сард тус тус тооцон шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Радио телевизийн Үндэсний сүлжээний Баян-Өлгий аймгийн Радио телевизийн сүлжээний газартай Ховд аймгийн Орон нутгийн 4 телевизийн нэвтрүүлгийг 200Вт чадалтай дахин дамжуулах станцаар дамжуулж иргэд, хэрэглэгчдэд хүргэхээр байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан /Х.Алтантуяа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ